



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/104

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 58 дугаар зүйлийн 58.2.17; Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.3, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймагт түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, Чингис хааны түүхийг гадаад дотоодын жуулчдад сурталчлан таниулах, нутгийн иргэдийн аялал жуулчлалаас олох ашиг орлогыг нэмэгдүүлж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох зорилготой боловсруулагдсан "Чингис брэнд" дэд хөтөлбөрийн хүрээнд 108 метр эсгийн дээр "Монголын нууц товчоо"-г шигтгэн урласан түүхэн бүтээл дуусч нээлтийн ажиллагаа зохион байгуулах болсонтой холбогдуулан хөрөнгө зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах 3532500 /гурван сая таван зуун гучин хоёр мянга таван зуун/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, арга хэмжээг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 501

03 Аймгийн Засаг даргын 2017 оны
дугаар сарын 11 өдрийн
дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Мөнгөн дүн /төгрөг/
1.	Гадаад, дотоодын зочдод зориулсан хүндэтгэлийн хүлээн авалт	90	19000	1710000
2.	Ирсэн зочдод зориулсан гарын бэлэг/сувинерь/	4	50000	200000
		37	30000	1110000
		19	25000	475000
3.	Зочдод олгох мандат	75	500	37500
4.	Нийт			3532500